



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/70

Бор-Өндөр сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Бор-Өндөр сумын 2026 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх “Гэрэлтүүлгийн засвар”-ын ажлын гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ч.Саруулмөнх

Нарийн бичгийн дарга:

Д.Мөнгөнтуяа

Гишүүн:

Э.Эрдэнэбат

“Уурхайчин” дүгээр багийн Засаг дарга

Бумбат 3 дугаар багийн Засаг дарга

“Бор-Өндөр хот тохижилт” ОНТҮГ-ын дарга

2. Бор-Өндөр сумын 2026 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх “Гэрэлтүүлгийн засвар”-ын ажлын гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа зохих хууль журмын дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Ч.Саруулмөнх)-д даалгасугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Галбадрах)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ОТГОНЦЭЦЭГ